

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2016-04-22/**

Ажлын хэсгийн 40 дүгээр хуралдаан 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 11.00 цагт Уул уурхайн яамны хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Батбаяр, Уул уурхайн яамны СТБГ-ын дарга М.Баянмөнх, ЭЗСХО-ын хэлтсийн дарга, ОУИТБС-ын ОУ-ын Удирдах хорооны гишүүн Н.Энхбаяр, Сангийн яамны мэргэжилтэн Г.Зулай, Газрын тосны газрын хэлтсийн дарга Б.Оюун, Татварын ерөнхий газрын хэлтсийн дарга Д.Цогзолмаа, ТАН эвслийн зохицуулагч Д.Эрдэнэчимэг, Ариун суврага хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Монголын Байгаль эхийн аврал сан ТББ-ын тэргүүн Б.Наранцэцэг, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, МБОИЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Эрдэнэс таван толгой ХК-ны гадаад харилцаа, орон нутаг, олон нийттэй харилцах хэлтсийн дарга П.Гэрэлтсансар, Арева Монгол ХХК-ны мэргэжилтэн Ц.Энхжаргал, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайханыг орлож, ТАН эвслийн гишүүн Д.Цэрэнпүрэв нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 16 гишүүн оролцож ирц 48,5 хувьтай байв.

Мөн хуралдаанд санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг болон Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Хурлыг Уул уурхайн яамны СТБГ-ын дарга Н.Энхбаяр удирдан явуулав.

Н.Энхбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе, Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн 40 дүгээр хуралдаан эхлэхэд бэлэн боллоо. Журмын дагуу ажлын хэсгийн хурлын хөтөлбөр, дотоод журмыг уншиж танилцуулъя. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал гишүүдэд байна уу? Байхгүй бол хэлэлцэх асуудлаа батлаад, хөтөлбөрийн дагуу нэгдүгээр асуудлын талаарх ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон мэдээлэл хийнэ.

Үүнээс өмнө хүсэлтийн дагуу 2016 онд Эрдэс баялагийн салбарт Уул уурхайн яам болон Төр засгаас баримталж байгаа бодлого, хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагааны талаар товч мэдээлэл өгье.

Монгол улс эрдэс баялагийн нөөц баялаг ихтэй, эдийн засгийг хөгжүүлэх бүрэн боломж бий, гэвч сүүлийн жилүүдэд үнэ ханш бууралттай, зах зээлийн эрэлт хэрэгцээтэй холбогдуулаад түвшин түвшиндээ санхүүгийн хүндрэл бэрхшээл, даван туулах хүнд сорилтууд гарч ирсэн. Энэ хүндрэлтэй байдлыг шийдвэрлэх зорилгын хүрээнд төр засгийн зүгээс хэд хэдэн чиглэлийн бодлогын арга хэмжээ авч, хэрэгжүүлж ирсэн. Юуны өмнө гол ач холбогдол өгч, анхаарал хандуулж ирсэн асуудал бол салбарын хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр нилээд ажлууд хийгдсэн. 2014 он УИХ-аас Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогыг баталснаар салбарын урт хугацааны бодлого тодорхой ойлгомжтой болсон. Энэхүү бодлогын баримт бичиг дээр тулгуурлаад Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга хийснээр батлагдсан. Монгол улс хуулиудаа гэнэт шинэчилдэг, өөрчилдөг тохиолдол урьд өмнө нь байсан. Гол төлөв шийдвэрүүд гэнэт гарахдаа салбарын үйл ажиллагааг зогсоох,

хумих, хязгаарлах хандлага гарч байсан. Үүний гол алдаа нь оролцогч талуудынхаа саналыг иж бүрэн байдлаар тусгаагүй, хэлэлцүүлэг нэгдсэн ойлголтод хүрэлгүйгээр шийдвэр гаргаж байсан, үр дүн төдийлөн сайн байж чадаагүй зэргээс шалтгаалсан. Харин сүүлийн жилүүдэд хийгдсэн хууль эрхзүйн шинэчлэл нь дээрх асуудалд онцгой ач холбогдол өгч ажилласан. Аж ахуй эрхлэгч компаниуд, хөрөнгө оруулагчид, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, олон улсын байгууллагууд оролцогч бүхий л талуудынхаа саналыг иж бүрэн байдлаар судалж, олон удаагийн хэлэлцүүлэгийг хийж ирснээр өнөөдрийн байдлаар эрдэс баялгийн салбарт бүрдээд байгаа орчин, өрсөлдөх чадвар нэмэгдсэн, салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэх боломж бүрдэж чадсан гэсэн нийтлэг ойлголт байдаг.

Дараагийн нэг үйл ажиллагаа нь эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх, тэлэхэд нилээд ач холбогдол өгч ажилласан. Бидний хамгийн гол худалдан авагч тал нь Хятад улс, гол нийлүүлэгч улс нь ОХУ байдаг. Эдгээр улсуудтай төр засгийн өндөр, дээд хэмжээний уулзалт хэд хэдэн удаа хийж, үүний үр дүнд томоохон шийдвэрүүд гарсан. БНХАУ-тай урт хугацааны туршид нүүрс худалдан авах урт хугацааны санамж бичиг байгуулсан, ОХУ-тай шатахуун нийлүүлэлтийн асуудлаар урьд өмнө зах зээлийн зарчимд нийцсэн байдлаар зохицуулагдаж чаддаггүй байсан асуудлаар тохиролцоонд хүрч, агуулгыг шинэчилсэн, шатахууны суурь үнийг цэвэр биржийн үнэ дээр тулгуурлан худалдан авах асуудлаар шийдэлд хүрсэн. Зөвхөн хөрш зэргэлдээ орнуудаас гадна түнш бусад орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн, тухайлбал Япон улстай түүхэндээ анх удаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг байгуулсан. Зөвхөн худалдааны асуудлаас гадна хөрөнгө оруулалт зэрэг иж бүрэн байдлаар хэлэлцээр хийсэн. Түүнчлэн Канад улстай хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах талаар хэлэлцээр хийсэн, үүнээс гадна 2015 оны 10 дугаар сард хийсэн хоёр орны Засгийн газар хоорондын хуралдааны үеэр Монголын талаас хамтран төсөл хэрэгжүүлэх санал тавьсанаар төсөл хэрэгжүүлэх шийдвэр гарсан. Австрали улстай Эрдэс баялгийн засаглалыг хөгжүүлэх чиглэлээр 5 жилийн хугацаатай төсөл нийтдээ 2 томоохон төсөл хэрэгжүүлэхээр болсон. Англи улсын “Экспорт финанс” гэдэг байгууллагын хүмүүс манай улсад ирж, хамтран ажиллах санал тавьсан. Энэ нь манайхаар Хөгжлийн банктэй дүйцэхүйц томоохон байгууллага бөгөөд хөгжлийн санхүүжилт олгодог бусад орнуудын тавьдаг саналаас илүү таатай нөхцлийг манайд санал болгосон. Зөвхөн зээлээр зогсохгүй хувьцаагаарх хөрөнгө оруулалт, батлан даалт зэрэг хэлбэрүүдээр санхүүжилт хийх ба үндсэн зээлийн нөхцөл нь зээлийн хүү нь Английн засгийн газрын бондын хүүтэй ижил хэмжээтэй байх, улс орнууд хөгжлийн санхүүжилт олгохдоо тухайн зээлийн хөрөнгөөр худалдан авах бараа үйлчилгээний 70-80 хувийг тухайн улсаас худалдаж авах шаардлага тавьдаг, харин тус байгууллага үүнийг 50 хувь байх зэрэг таатай саналуудыг тавьсан байна. Энэ санхүүжилтийн хүрээнд санхүүжилт авахаар хэд хэдэн аж ахуйн нэгжүүд гэрээ хэлэлцээрийг байгуулж байна, удахгүй тус байгууллагатай санамж бичиг байгуулна. Герман улстай уламжлалт хамтын ажиллагаа явагдаж байгаа, эрдэс баялагийн бирж байгуулах чиглэлээр хамтарсан төслийг хэрэгжүүлээд явж байна.

Он гарснаас хойш, Хятад улстай хийсэн хэлэлцээрийн үргэлжлэл болгоод БНХАУ-ын 13 дахь таван жилийн төлөвлөгөөнд Монгол улсын эрдэс баялагийн салбарын экспортын талаар хамтран ажиллах тоо, тооцооллыг тусган уялдуулах чиглэлээр тохиролцсон. Бид урт хугацаанд хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж, тус улсын Үндэсний хөгжлийн шинэтгэлийн хороо болон Худалдааны яам, Газар байгалийн баялагийн яамдуудтай уулзалтуудыг хийж, энэ асуудлаар тохирсон. Дэд ажлын комисс хуралдаж, эдгээр ажлуудыг

баталгаажуулсан, Засгийн газар хоорондын комисс энэ оны 5 дугаар сард хуралдана. ОХУ-тай эрдэс баялагийн салбарын хамтын ажиллагааны хүрээнд, Монгол улсын нутаг дэвсгэр дээр 1960-1990 оны хооронд ОХУ-ын геологийн албадууд олон тооны судалгаа хийсэн байдаг. Тэр судалгааны тайлангийн баримт материалуудыг тухайн үедээ хүлээлгэн өгөлгүй, буцаан авч явсан. Үүнийг Монголын талд шилжүүлж өгөх асуудлаар нилээд олон жилийн турш ярилцаж байсан ч төдийлөн нааштай шийдвэр гардаггүй байсан бол Засгийн газар хоорондын комиссийн уулзалт өнгөрсөн жилийн 12 сард Читон хотноо болсноор тайлангуудыг Монголын талд шилжүүлэхээр тохиролцсон. Дэд ажлын хэсгийн хуралдааныг 2016 оны 3 дугаар сард Москва хотноо болон Санктпетрбург хотноо хийж, үүгээр Монголтой холбоотой нийт 1023 баримт материалыг иж бүрнээр, үнэ төлбөргүйгээр, нууцын зэрэглэлийн материалыг оролцуулаад хүлээлгэн өгөх болсныг хэлэхэд таатай байна. Эдгээр материалуудыг хүлээн авснаар Монгол улсын Геологийн шинжлэх ухааны салбарт хөгжлийн нэгэн үе шат нээгдэх, мөн суурь судалгааны мэдээллийг олон нийтэд нээлттэй танилцуулснаар геологийн салбарт хөрөнгө оруулалт татах томоохон нөхцөл бүрдүүлнэ гэж бид харж байна.

Хууль эрхзүйн шинэчлэлийн асуудлууд үргэлжилж байгаа. Үүнийг илүү үр дүнд хүргэх чиглэлээр бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Бодлогын арга хэмжээний хувьд татварын бодлогод нилээд уян хатан бодлогыг хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, алтын салбарт рояалтигийн хувь 10 хувь байсныг 5 хувь болгосон. Ингэснээр сүүлийн жилүүдэд алтны олборлолтын хэмжээ өмнөх жилүүдтэй харьцуулахад 2 дахин, хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад 4-5 дахин нэмэгдсэн байна. Жилдээ хамгийн багадаа 2-3 тонн байсан алтны олборлолт 10 гаруй тонн болон нэмэгдсэн байна. Эрдэс баялагийн салбарт оруулж ирэх машин, тоног төхөөрөмжийн худалдааны татварыг 2018 оныг дуустал тэг хувь болгосон. Эрдэс баялагийн салбарын орлогоос уул уурхайн үйл ажиллагаа төвлөрч байгаа аймаг, сумдуудад рояалтигийн 30 хувь, тусгай зөвшөөрлүүдийн 50 хувийг төвлөрүүлэх зохицуулалт хийгдсэн. Улсын чанартай томоохон ордуудын жагсаалт гарсан, үүнд Эрдэнэт, Оюутолгой, Таван толгойн орлого нэдсэн төсөвт төвлөрүүлэх, бусад төслүүдийн орлого тухайн орон нутагтаа үр өгөөжөө шууд хуваарилахаар эрхзүйн нөхцөл бүрдсэн.

Одоо хуралдааны үндсэн асуудал руу оръё. Нэгдүгээр танилцуулгыг ажлын хэсгийн зохицуулагч Цолмон таницлуулна.

Д.Эрдэнэчимэг: Энхбаяр даргын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж болох уу?

Ш.Цолмон: Болно, аль болох товчхон

Д.Эрдэнэчимэг: Урт нэртэй хуульд өөрчлөлт орсон, үүний дагуу хуулийн үйлчлэх хүрээнд тусгай зөвшөөрөл нь түдгэлзсэн байсан аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрөл сэргээж байгаа. Үүнтэй холбоотойгоор УУЯ, БОНХАЖЯ, орон нутгийн захиргаатай хамтарсан гурван гэрээ байгуулах болсон, гэрээний загвар боловсруулагдаж байгаа гэсэн үүний ажлын явц ямар шатандаа байна вэ? Хоёрдугаарт, өнгөрсөн оны сүүлээр Ашигт малтмалын хуулинд өөрчлөлт орно гээд хэд хэдэн төслүүд танилцуулагдаад явж байсан, энэ хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил хаана явж байна, үүнд ИНБ-ууд санал өгч оролцох бололцоо байна уу? Мөн ОУ-ын байгууллагуудтай хэрэгжүүлэх төслүүд яригдлаа. Канадын 8,4 сая долларын өртөгтэй төсөл маань ямар төсөл байсан бэ? Гуравдугаарт, Хөгжлийн албан ёсны зээл тусламж үзүүлж байгаа донор орнууд болон тусламж хүлээн авч байгаа орнуудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон, тусламжийн үр нөлөөг

нэмэгдүүлэх талаар олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцүүлэгүүд их болж байгаа. Энэ хэлэлцүүлгээр Гана улсын Акрад болсон хуралдааны үеэр донорууд болон Засгийн газруудад хөгжлийн албан ёсны тусламжийн үр нөлөөг нэмэгдүүлэх, энэ хүрээнд ИНБ-уудын хөгжлийг дэмжих талаар донорууд болон Засгийн газруудын үүрэг хариуцлагыг тодорхойлсон бодлогын баримт бичгийг батласан. Үүнд хөгжлийн бодлогын зээл тусламжийг өгөхөд ИНБ-уудын оролцоог хангах, чадавхийг бэхжүүлэхэд анхаарч, зээл тусламжийгн үр нөлөөг нэмэгдүүлэхэд иргэний нийгмийн хөндлөнгийн хяналт чухлыг тодорхойлсон байгаа. Өөрөөр хэлбэл УУЯам Канадын Засгийн газартай хамтраад төсөл хөтөлбөрт хэрэгжүүлж байгаа бол энэ төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих Иргэний нийгмийн оролцоог яаж хангах вэ? Үүнтэй холбоотой иргэний нийгмийн чадавхийг яаж бэхжүүлэх вэ гэдэг асуудлыг зээл тусламж, хөгжлийн хэлэлцээрийн үеэр давхар шийдэж явах ёстой гэсэн үг. Үүнийг албан ёсны үүрэг гэж ойлгож байна. Одоо төлөвлөгдөж байгаа төслүүд дээр Иргэний нийгмийн хяналт, оролцоотой холбоотой ямар ажлууд байна вэ? гэдгийг танилцуулна уу.

Сүүлийн үед УУЯ-наас бодлогын чиглэлтэй олон баримт бичгүүдийг баталж байна, үүнд иргэний нийгмийн оролцоо байхгүй байна. Тухайлбал, Алт-2025 хөтөлбөр батлагдсан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиараа байгаль орчинд нөлөө бүхий төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд байгаль орчны нөлөөллийн стратегийн үнэлгээ хийх ёстой. Стратегийн үнэлгээнд орон нутаг, иргэний нийгмийн оролцоог хангах журам байгаа, энэ журам мөрдөгдөхгүй байна. Бид ОУИТБС-ын ажлын хэсэг, Үндэсний зөвлөл энэ бүтцийнхээ хүрээнд ОУИТБС-тай холбоотой шийдвэр гаргахад ИНБ-ууд хангалттай оролцож байгаа, энэ тогтсон хамтын шийдвэр гаргах механизмаа салбарын бодлого шийдвэр гаргахад ашиглаж явмаар байна. Яагаад гэвэл ОУИТБС нь тайлагналтаас өөрчлөлт рүү болсон иймээс бид бодлогын өөрчлөлтөд анхаарч ажиллах нь байна. Иймээс ИНБ-уудын оролцоог хангах тал дээр анхаарч өгөөч гэсэн саналтай байна.

Н.Энхбаяр: Асуулт, саналыг хүлээн авлаа. Хурлын асуудлаа хэлэлцээд дараа нь хариултыг өгье.

Хуралдаанд ОУИТБС-ын Ажлын хэсгийн ахлагч, Ерөнхий сайдын ахлагч Б.Батбаяр хүрэлцэн ирлээ.

Ш.Цолмон: Танд хуралдаанд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын олон улсын бага хуралд оролцсон дүн болон шинэчилсэн стандартын тухай

Ш.Цолмон: ОУИТБС-ын дээд байгууллага нь ОУИТБС-ын бага хурал байдаг. Энэ удаа 7 дугаар бага хурал Перу улсын нийслэл Пима хотноо болсон. Тус хуралд Монгол улсын Засгийн газрын гишүүн, Уул уурхайн сайд, Үндэсний зөвлөлийн орлогч дарга Р.Жигжид тэргүүтэй 7 хүний бүрэлдхүүнтэй төлөөлөгчид оролцсон. Бага хуралд дэлхийн 100 гаруй орны 1200 орчим төлөөлөгч оролцсон ба хурлын уриа нь “ОУИТБС-ын тайлангуудыг үр дүн болгоё” гэсэн сэдэвтэй байлаа. Монгол улсыг ОУИТБС-ыг мэдээллийн хүртээмж, хангамжийг бусад орнуудаас илүү сайжруулсны төлөө ОУИТБС-ын Даргын нэрэмжит цомоор шагнасан. Хурлын үеэр манай төлөөлөгчид ХБНГУ-ын ЭЗЭХЯ-ны Парламент

дахь Төрийн нарийн бичгийн дарга, Перу улсын УУЭХ-ны сайд, дэд сайд нар, Колумб улсын УУЭХ-ны дэд сайд, Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэнгийн ерөнхийлөгч зэрэг дээд албан тушаалын хүмүүстэй уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны талаар ярилцаж, хамтран ажиллах тухай хэлэлцсэн байна. Мөн Казахстан, Кыргызстан Украйны ОУИТБС-ын дээд удирдлагуудтай уулзаж, мэдээлэл байнга солилцохоор тохиролцсон байна. Тус бага хурлаас ОУИТБС-ын Удирдах хорооны 2016-2019 оны шинэ бүрэлдхүүнийг баталж, даргаар ноён Фредрик Рейнфелдтийг томилсон байна. Түүнчлэн ОУИТБС-2013 стандартыг шинэчилж, 2016 стандартаар солихоор болсон, ОУИТБС-ын хэрэгжүүлэгч орнуудын зохицуулагч нарын байнгын ажлын хэсгийг байгуулахаар болж, байнгын эргэх холбоотой ажиллах журмыг хэрэгжүүлэх зэрэг шийдвэрүүдийг гаргасан байна.

Тус бага хурлаар ОУИТБС-ын 2016 стандартыг баталж, ОУИТБС-ын ОУНБДнГ-аас 2016 оны төлөвлөгөө, холбогдох сургалтын төлөвлөгөөний дагуу ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэхэд мэдлэг чадавхитай болгох чиглэлээр шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх, ашиг хүртэгч эздийг гишүүн орнууд 2020 оны 1 сарын 1-нээс ил тод болгох, ОУИТБС-ын Удирдах хороо нээлттэй мэдээллийн талаар бодлого боловсруулж, стандартыг тогтоохоор ажиллах бөгөөд энэ ажилд Олон улсын валютын сангаас дэмжлэг үзүүлэхээр болов.

Шинэ стандартыг хэрэгжүүлэх хүрээнд 2016 оны 2 дугаар сарын 23-наас хүчин төгөлдөр болж байна. ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч гишүүн орнууд дараах ажлыг аль болох богино хугацаанд хэрэгжүүлэн шилжинэ. Үүнд, ОУИТБС-ын тайлангуудаар гарсан бүх зөвлөмжийг ажлын төлөвлөгөөнд тусгасан байх, 2017 онд Баталгаажуулалтад орох орнууд энэ шаардлагыг хангасан байх, жил бүрийн ахиц дэвшлийн тайланд энэхүү шаардлагыг хир хангасан, ажлын төлөвлөгөөндөө оруулсан эсэх хэрэв оруулаагүй бол үндэслэлийг тайлбарлах үүрэгтэй. Монгол улс 2016 оны 4 дүгээр сарын 1-нээс Баталгаажуулалтад орно. /Танилцуулгыг хавсаргав/

Н.Энхбаяр: За баярлалаа, асуулт асуух гишүүд байна уу?

Д.Эрдэнэчимэг: Ашиг хүртэгч эздийн мэдээллийг ил тод болгох газрын зураг гэж юуг ойлгож байна вэ? Road map -ийг авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө гэж ойлгож байгаа.

Ш.Цолмон: Зөв, би үүнийг дараагийн танилцуулга дээр тодорхой хэлнэ. Орчуулгын хувьд бид бас тохирох хэрэгтэй юм байна лээ.

Б.Батболд: Манай ИНБ-ыг төлөөлж Эрдэнэчимэг бага хуралд оролцсон. Ямар учраас, яагаад бүх гишүүдийн зөвлөгөөнд оролцоогүй юм бол?

Д.Эрдэнэчимэг: Монголын тан эвсэл нь Төлснөө нийтэл гэсэн ОУ-ын сүлжээ байгууллагын гишүүн байгууллага юм. Тэнд 90 гаруй орны гишүүн байгууллага оролцсон. Энэ удаагийн хурлаар ОУИТБС-ын Удирдах хорооны шинэ бүрэлдэхүүнийг баталсан. Удирдах хорооны бүрэлдэхүүнд иргэний нийгмийн 5 гишүүн байх ёстой, энэ төлөөлөгчдийг ИНБ өөрсдөө нэр дэвшүүлдэг журамтай. Тодорхой процедурын дагуу 5 хүнийг нэр дэвшүүлээд гаргасан байхад 6 дахь хүн гарч ирсэн. Энэ хүн хууль ёсны дагуу биш, өөрөө нэр дэвшүүлээд ороод ирэхэд нь ОУ-ын НБДнГ хүлээн авсан. Тэр нэр дэвшигч байгууллага нь “Олборлох

үйлдвэрлэл эрхлэгчдийн ИНБ” гэдэг нэртэй, яг ямар байгууллага гэдэг нь тодорхойгүй, өөрөөр хэлбэл жинхэнэ ИНБ мөн үү эсвэл ассоциаци шиг уул уурхайн компаниудын холбоо юу гэдэг нь тодорхой бус байсан. Засаглалын хүрээнд гурван талын тэгш оролцоог хангана гэсэн том зарчмыг ийнхүү зөрчсөнийг ОУ-ын бүтцийн хүрээнд засаглалын хямрал гарлаа гэж үзсэн. Иймээс 6 дахь нэр дэвшигчийг эргүүлж татахаас нааш хуралд оролцохгүй гэсэн шийдвэр гаргасан. Үр дүнд нь 6 дахь нэр дэвшигчийг буцаан татсан байгаа, гэхдээ түүнийг хүлээн авсан процедур нь өөрөө хууль бус байсан учраас ОУНБДнГ-ыг буруугаа хүлээн зөвшөөрөх шаардлага тавьсан, яагаад гэвэл дараа дахиад ийм асуудал гарч магадгүй, олон улсын хэмжээнд ийм засаглалын хямрал гарвал үндэсний хэмжээнд муу үлгэр дууриалал болно гэдэг үүднээс ийм шаардлага тавьсан. Энэ асуудлын хүрээнд шинээр сонгогдсон Удирдах хороон дээр нэн түрүүн авч хэлэлцэх үүргийг шинэ дарга нь хүлээсэн байгаа. Цаашдаа ямар шийдвэр гаргаж, ямар үр дүнд хүрэхийг Удирдах зөвлөлийн гишүүн Энхбаяр мэдээлээд явах байх, одоогоор бидэнд мэдээлэл байхгүй байна.

Н.Энхбаяр: За дараагийн асуудалдаа оръё.

ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын олон улсын шинэчилсэн стандартын хүрээнд ашиг хүртэгч эздийг ил тод болгох тухай Ажлын дэд хэсэг байгуулах тухай

Ш.Цолмон:Баярлалаа, энэ асуудал маань нилээд ярвигтай, төвөгтэй асуудал байгаа. энэ асуудлын хүрээнд ашиг хүртэгч эздийн тодорхойлолт, яагаад ил тод болгох ёстой вэ? Ашиг хүртэгч эздийн ил тод байдал ба ОУИТБС, ашиг хүртэгч эздийг ил тод болгох замын зургийг гаргах тухай, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч танилцуулъя.

Ашиг хүртэгч эзэн гэдэг нь компанийн хувьд тухайн аж ахуйн нэгжийг шууд буюу шууд бусаар эзэмжих буюу хянадаг хувь хүнийг хэлнэ. Ашиг хүртэгч эздийг ил тод болгосноор хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, улсын нэр хүндийг бууруулах эрсдэлээс сэргийлэх, авилга, санхүүгийн хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хуулийн засаглалыг сайжруулах, итгэлийг нэмэгдүүлж, хариуцлагатай байдлыг сайжруулах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна. ОУИТБС-ын стандартад ашиг хүртэгч эздийн бүртгэлийг ил тод болгохыг шаардах болсон. Монгол улсын хувьд ОУИТБС-ны 2013 оны тайланд 215, 2014 оны тайланд 26 компаниас энэ тухай мэдээллийг авч, хэвлэн нийтэлж 2013 оны өгөгдлөөр дүрст мэдээллийг боловсруулж, Ажлын албаны цахим хуудсанд байршуулсан. Хэрэгжүүлэгч орнууд ОУИТБС-ын тайлангаар хууль ёсны хувьцаа эзэмшигчид, тэдний хувь эзэмшлийг мөн ил тод болгох үүрэг хүлээнэ.

Ашиг хүртэгч эздийг ил тод болгох замын зургийг гаргах ажлын хүрээнд ашиг хүртэгч эздийг ил тод болгох асуудлыг шинэчлэлийн бодлогын гол чиглэлүүдтэй холбож өгөх, ашиг хүртэгч эздийг ил тод болгох байгууллагын тогтолцоог тодорхойлж өгөх, тодорхойлолтыг бий болгох, холбогдох мэдээлэл цуглуулах, сан бий болгох, техникийн болон санхүүгийн дэмжлэгийн тооцоог гаргах, замын зурагт орсон үйл ажиллагаануудын хэрэгжсэн байх хугацаа, хариуцлага, хариуцах эздийг тодорхойлж өгөх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай. Дээрх ажлын хийж хэрэгжүүлэх Үндэсний ажлын хэсгээс дэд хэсэг байгуулан ажиллах саналтай байна. Энэ дэд ажлын хэсэг нь оролцогч тал бүрийн

хэрэгцээ сонирхолыг нэгтгэн газрын зураг хэмээх 2017-2019 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан, Ажлын хэсэгт танилцуулах юм. Эдгээр асуудлуудад та бүхэн саналаа өгнө үү.

Б.Батбаяр: Олон нийтийн байгууллага гэдэг нь ТББ биз дээ. Энэ гурван талын оролцоог хангах иргэний байгууллагын шалгуур нь юм байдаг вэ? Ямар нь ордог, ямар нь ордоггүй юм. Одоо монгол улсад 27,000 иргэний нийгмийн байгууллага байдаг, үүнээс зөвхөн гол горхи, уул нурууг хамгаалах нь 600 гаруй байгаа. Энэ ажлын хэсэгт ямар ордог юм бол, сэргэлэн нь ордог юм уу? Хоёрдугаарт, тухайн ИНБ нь ашиг сонирхолтой байх ёстой, зүгээр л хийх юм олдохгүйдээ цугладаггүй байлгүй, яагаад ийм олон байгууллага байгуулаад байдаг юм, дунджаар нэг ИНБ-д оногдож байгаа хүний тоо давхардсан тоогоор 1,2 байдаг. Гуравдугаарт, ямар ашиг сонирхолоор энд орсон юм, ямар нэгэн шалгууртай байх ёстой байх. Хамгийн их ИНБ-тай орон бол Нигер улс, 150000 гаруй байна. Нэг компаниас 50 эсвэл 100 байгууллага ашиг хүртэж байдаг. Нигер нь маш сайн судлагдсан, нефть олборлолтоор хамгийн баян орон. Дараа нь ИНБ-ийн эрх үүрэг гэж юу байдаг юм бэ? Хутаг шөвөгтэй буудаад л байдаг газрыг хэлдэг юм уу? Манайд тийм шалгуур байхгүй, би энэ байгууллагыг төр, компани, иргэний нийгмийн хамтын ажиллагаа гэж ойлгож байгаа. Компани, төр хоёр хамгийн ойлгомжтой байгаа харин нөгөөдөх нь ямар шалгуураар ирсэн хэнийг төлөөлж байгаа юм бэ? 1,2 хүнийг төлөөлж байгаа юм уу? Ер нь бол хамгийн идэвхтэй, шантаажны байгууллага байсан, цаашдаа ч байх л байх. Одоо бидэнд гаднын хөрөнгө оруулалт байхгүй болсон, гол буруутан нь ИНБ гэж би хардаг. Энд ил тод биш сүлжээ яваад байна. Урт нэртэй хуульд олон компаниуд оролцсон, очоод юм ухахад олдохгүй бол алдагдлаа улсаар төлүүлчихье гэсэн. Тэр алдагдлыг тооцоолоход 7,4 тэрбум төгрөг гарсан, үүнийг төлөх мөнгө манай улсад байхгүй. Улс бүр мөнгөгүй болчихоор шантаажлах ч юм байхгүй боллоо.

Би та нартай маргах гээгүй, дураараа болцгоо, ганцхан энэ чинь улс орныхоо төлөөх хамтын ажиллагаа шүү, хэрвээ ямар нэгэн шалгуур байхгүй, зорилго байхгүй бол хамтын ажиллагааг болж чадахгүй. Баярлалаа, би дахин орохгүй байх, дараагийн сараас зөвлөхөө больчихно. Та бүхэн хамтын ажиллагааг гэдгээ л сайн ойлгоорой. Жишээлбэл, та ямар зорилгоор ТББ байгуулсан юм бэ? Зөвхөн эх орондоо хайртай гэдэг чинь тайлбар биш шүү. Би та нартай маргах гээгүй

Н.Наранцэцэг: Бид нар ч тодорхой зорилготой, дураараа байгуулаагүй. Хэн дуртай нь орж ирээд дайраад байх ёсгүй.

Б.Баярмаа: Та бол биднийг хичнээн жил дайрч, доромжилж байгаа.

Б.Батболд: Танай засаглалын байж байгаа царай, ийм хүнээр зөвлөх тавьчихаад л, та ч гэсэн тийм юманд ороод сууж байдаг, ерөнхий сайдын ахлах зөвлөхөө болиоч.

Г.Чагнаадорж: Та тийм юм ярьж болохгүй.

Б.Батболд: Та төрийнхөнийгээ ирүүлж чадахгүй байна.

Б.Батбаяр: Би зүгээр АСЕМ-д туслах гэсэн юм, түүнээс энд оролцох гээгүй.

Б.Батболд: Тэгвэл та ашиг сонирхолтой л очоо байлгүй.

Б.Баярмаа: Бидний ярьж байгаа юманд иргэдийн оролцоо чухал шүү. Та уул уурхайгаас мөнгө аваад л хагартлаа баяжихаад бидний доромжилж байсан.

М.Баянмөнх: За би Уул уурхайн яамны СБТГ-ын дарга, төмөр зам дээр нилээн ажилтай байгаад хожигдоод ирчихлээ, хүлцэл өчье. Уг нь би хурлыг удирдаж явуулах үүрэгтэй байсан. Хурлын төлөвлөгөөний дагуу асуудлууд танилцуулагдсан тул асуулт асуух хүмүүс байвал асуугаад, шийдвэрээ гаргая.

Б.Батболд: Стандарт 2,5-д зааснаар 2020 он гэхэд ашиг хүртэгч эздийн мэдээллийг тайлангаар ил тод болгосон байна гэсэн байна. Гэхдээ бид арай наана нь өөрсдийн хүрээнд ил тод болгох боломжтой юу?

Ш.Цолмон: Зарчмын хувьд болно, гагцхүү техникийн хувьд яахыг сайн мэдэхгүй байна. Тийм учраас дэд хэсэг байгуулаад, энэ талын бүх судалгааг хийнэ, нэг талаас нээлттэй нийгэм хүрээлэн дээр томоохон судалгаа хийнэ, нөгөө талаар Баярмаа томоохон судалгаа хийсэн байгаа. ингээд гурван талаасаа хамтраад ямар мэдээлэл болсон байна, юу хийх шаардлагатай байна гэдгээ тодорхойлоод, шийдвэрээ гаргаад ажиллах байх. Заавал 2020 оныг хүлээх шаардлагагүй, хууль эрхзүйн хувьд нилээд ажил хийх шаардлагатай байх гэж харж байгаа.

Б.Баярмаа: Ашиг хүртэгч эздийг ил тод болгох туршилтын төсөл 11 оронд хэрэгжүүлсэн байна. Эдгээр орноос гарсан сургамж, мэдээллийг бид үзэх боломжтой юу? Хууль маань ямар түвшинд явж байна вэ?

Ш.Цолмон: Эрдэс баялгийн ил тод байдлын хууль маань энэ долоо хоногт чуулганаар хэлэлцэгдэх хуваарь гарсан боловч хойшилсон дараа долоо хоногт орох байх гэж найдаж байна. Тэр хуулинд энэ талаар орсон зүйл одоогоор байхгүй. Хуулийн этгээд, компани гэдэг байдлаар явж байгаа, үүнийг дараа нь тусад нь ярьсан нь дээр байх.

Г.Чагнаадорж: Ашиг хүртэгч эздийг тодорхойлох гэдэг дээр хувь хүнийг хэлнэ гээд байх юм. Миний бодлоор компанид ТУЗ-ын гишүүд, хөрөнгө оруулагчид гэж байдаг юм байна лээ, хувь хүн гэдэг чинь тухайн компанид хөрөнгө оруулсан хүнийг хэлэх үү?, хянадаг хүн гэхээр хэн нь орох вэ? Үүнийг сайн ойлгохгүй байна.

Ш.Цолмон: Ашиг хүртэгч эзэн гэдэг нь компанийн хувьд тухайн аж ахуйн нэгжийг шууд буюу шууд бусаар эзэмших буюу хянадаг хувь хүнийг хэлнэ гэж заасан. Хувь гэдэг нь тодорхой, өмнө нь хувьцаа эзэмшигч гэхээр компани ч юм шиг ойлгож байсан, түүн дотроо төрийн өндөр албан тушаалтан, улс төрийн нөлөө бүхий зүтгэлтэн ч гэх юм уу утгаар ойлгогдоно. Одоохондоо ингэж ойлгож байгаад, ажлын хэсэг үүнийг тодорхой болгоод танилцуулах байх.

Д.Эрдэнэчимэг: Стандарт дээр байгаа тодорхойлолтыг харахад энгийн юм шиг байгаа, гэхдээ маш нарийн. ОҮИТБС-ын мэдээлэл тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр хязгаарлагдаж байсан бол ашиг хүртэгч эздийн мэдээлэл нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс гадна олборлох салбарын тендерт оролцсон, хөрөнгө оруулсан болон олборлох салбарт холбоотой үйл ажиллагаа эрхэлж байгаа компанийг шууд болон шууд бусаар эзэмшиж байгаа, удирдлага хяналтанд шууд бусаар оролцож байгаа бие хүн, үүн дотроо улс төрд нөлөө бүхий этгээдийг онцолж гаргаж ирэх ёстой гэсэн шаардлага байгаа. Бид юуны өмнө бенефициар

өмчлөгч гэдэг тодорхойлолтоо гаргаж ирээд, энэ тодорхойлолтод хамрагдаж байгаа ямар мэдээллийг ил тод болгох хэрэгтэй вэ гэдэг дээр тохиролцоонд хүрээд, тэр мэдээллийг яаж ил тод болгох вэ, төрийн уялдаа холбоо ямар байх вэ гэдэг дээр санал нэгдэх хэрэгтэй юм байна.

Б.Баярмаа: Оролцогч талууд тохиролцох ёстой гэсэн байдаг, судалгаа хийж байх үед үнэт цаасны тухай хуулийнхаа дагуу 5 хувиар явъя гэдгийг тохиролцсон гэж үзэж байсан, гэтэл шинэ шаардлагаар бол ажлын хэсэг гараад бенефициар өмчлөгч гэдгийг юу вэ гэдгийг талууд нилээд нарийн хэлэлцээд, мэргэжлийн хүмүүсийн оруулаад, шууд бус хяналтын багц эзэмших хувь нь хэд байх юм бэ? зэргийг тохиролцох шаардлагатай байна, үүнийг тэр ажлын хэсэг хийх үү?

Ш.Цолмон: Тийм, ажлын дэд хэсэг нь танилцуулгад дурдсан 12 төрлийн асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, ажлын хэсэгт танилцуулах юм.

Н.Энхбаяр: 6 дугаар сарын 15-ны дотор ажлын хэсэгт юуг танилцуулах вэ?

Ш.Цолмон: Ажлын төлөвлөгөө, гарах зардал, хийгдэх ажлын чиглэлийг гаргах ёстой гэж ойлгож байна. Ажил судалгаа хоёр зэрэгцээд хийгдэх байх.

Д.Эрдэнэчимэг: Бид хамгийн цаад тал нь 2020 он гэхэд ашиг хүртэгч эздийн мэдээллийг ил тод болгох ёстой, тэр хүртэл 2018 он хүртэл ч юм уу хийх ажлын төлөвлөгөөг гаргах юм. Нээлттэй нийгэм форумас ашиг хүртэгч эздийн мэдээллийг ил тод болгох арга замыг тодорхойлох гэдэг судалгааны төслийн уралдаан зарлаад өнөөдөр гурван саналыг хүлээж аваад байна. Ирэх долоо хоногоос шалгаруулах байх, судалгаагаар бид монголын хувьд ашиг хүртэгч эзэд гэдгийг яаж тодорхойлж болох, ямар мэдээллийг ил тод болгож оруулах, ил тод болгоход хууль эрхзүйн ямар орчныг бүрдүүлэх шаардлагатай юм, аль байгууллага ямар эрх үүрэгтэй яаж хамтарч ажиллах вэ гэдгийг санал болгох юм. Судалгааны дүн Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд танилцуулагдана, цаашид бидний хийх зүйлд суурь нь болно гэсэн хүлээлттэй байгаа, төлөвлөгөөгөөр бол 7 сарын эхний долоо хоногт судалгааны тайланг хүлээн авна гэж үзэж байна.

Г.Чагнаадорж: Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэн гэдэг чинь Дорждарийн байгууллага уу?

Ш.Цолмон: Тийм, Дорждарь нилээд дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа.

Д.Эрдэнэчимэг: Дэд ажлын хэсгийг байгуулахад нилээд олон талын оролцоог хангаж ажиллах шаардлагатай. Холбогдох хуулиудыг харахад, Төв банкинд эцсийн өмчлөгч гэдгийг тодорхойлж, мэдээллийг бүртгэдэг юм байна, Санхүүгийн зохицуулах хороон дээр нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийг, хуулийн этгээдийн бүртгэлийн газарт үүсгэн байгуулагчид компанийн эздийг гэх мэт нилээд олон газарт ашиг хүртэгч эздийн мэдээлэл бүртгэгддэг юм байна. Зарим нь нууцын нилээд өндөр зэрэглэлтэй, зарим нь ил байна. Бид 2020 он гэхэд мэдээллийг ил тод болгоно гэхэд эдгээр байгууллагуудын хамтын ажиллагааг хангах нь чухал. Иймээс ажлын хэсэгт Үнэт цаасны хороо, банкнаас хүн оруулах шаардлагатай байна, ямар нэгэн байдлаар эдгээр байгууллагуудын оролцоог хангасан ажлын хэсэг байгуулж байж бид хаана ямар мэдээллүүд бүртгэгдэж байна, тэдгээрийг яаж нэгтгэх вэ гэдэг дээр шийдэлд хүрэх болов уу.

М.Баянмөнх: Бид ашиг хүртэгч буюу бенефициар өмчлөгч гэдгийн талаар ярьж байгаа, энэ нь нилээд хувь хүний болон компаниудын нууцтай холбоотой нилээд нарийн асуудал юм. Энэ тал дээр нилээд нухацтай судалж үзэж гаргахгүй бол болохгүй байх. Үүнийг цаашдын үйл ажиллагаандаа анхаарч ажиллах нь зүйтэй байх, өнөөдөр хэдийгээр ил тод гэж ярьж байгаа ч хувь хүний нууцад халдах, хөндөх эрх бидэнд байхгүй. Зөвшөөрсөн тохиолдолд болно.

Б.Баярмаа: Одоо ямар нэгэн хэмжээгээр өгч байгаа.

Ш.Цолмон: Хууль ёсны гэдгээрээ явж байгаа, хувь хүн гэдгээрээ.

Д.Эрдэнэчимэг: ОУИТБС-ын тайланд тусгаад урт жагсаалт гаргахаас илүүтэйгээр яг тухайн орны хувьд байгаа бүртгэл, хяналтын тайлагналын тогтолцоо руу нь шигтгэж өгөх хэрэгтэй. Хэрвээ хөрөнгийн бирж дээр хувьцаа эзэмшигчдийн жагсаалт нээлттэй байгаа бол бид түүнийг заавал тусад нь гаргаад байх шаардлагагүй.

Н.Энхбаяр: Бид дотооддоо ч хийж байгаа судалгаа байна, гадаадын 11 орны сургамж ч байгаа юм байна. Нэгэнт бенефициар ярьж байгаа тохиолдолд олон улсын хамтын ажиллагааны хүрээний асуудал их орж ирэх болов уу, судалгаа нь олон чиглэлээр байх нь ойлгомжтой, ажлын чиглэлээ гаргачихсан юм байна, гол нь ажлын хэсгийн бүрэлдхүүнээ тогтвол яасан юм бэ?

Ш. Цолмон: ОУ-ын Удирдах хорооны гишүүн Энхбаяр даргаар энэ ажлыг удирдуулах саналтай байна, цаашид энэ чиглэлээр ажиллах байх, Уул уурхайн яам энэ талаар гол төлөөллөөр ажиллах байх гэсэн саналтай байна. Үүнийг даргатай зөвшилцсөний үндсэн дээр дээрх саналыг оруулж байна. Төлөөллийн хувьд компани, иргэний нийгмээс ямар бүрэлдхүүнтэй оролцох талаар саналаа өгөх байх.

М.Баянмөнх: Ажлын хэсгийн бүрэлдхүүнд хэдэн гишүүн байх вэ гэдгээ тогтоод, цаашдаа цахимаар Энхбаяр даргад саналаа өгөөд шийдээд явсан нь дээр байх.

Б.Батболд: Төрийн байгууллагын төлөөлөл яагаад хуралд ирэхгүй байна, Санаачилгын нарийн бичгийн даргын байж байгаа царайг хар. Бид хурлыг үр дүнтэй явуулах үүднээс санаачилга гаргаж ажилмаар байна. Хуралд төрийнхөн цөөхөн, ИНБ-ийнхан ирээд хуралдахаар үр дүнгүй байна. Үүнийг үр дүнтэй болгох талаар арга хэмжээ авмаар байна, эсвэл иргэний нийгмийнхэн бид бичиг бэлдээд Ерөнхий сайдад хандвал яасан юм бэ? Том хуралд ирээд, жижиг хуралд ирэхгүй, гадаад явах болохоор алт, нүүрс гээд бүгд л давхиад ирдэг.

Ш.Цолмон: Тэр ч та бүхний эрх

Д.Эрдэнэчимэг: ОУ-ын Удирдах хорооноос баталгаажуулалтын нэгдсэн журам дээр санал нэгдэхгүй байгаа учраас баталгаажуулалт хойшлоод байгаа юм байна, гэхдээ 6,7 сараас хэтрэхгүй эхлэх нь тодорхой. Туршилтын баталгаажуулалтын дүнг харахад бид баталгаажуулалтыг давахад асуудалтай байгаа, нилээд олон асуудал дээр шаардлагыг хагас хангасан, хангаагүй гэсэн үнэлгээ авсан байгаа. Иймд туршилтын баталгаажуулалтын дүгнэлт, зөвлөмжийг Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн гишүүдэд албан ёсоор танилцуулаад, зөвлөмжийн мөрөөр жинхэнэ баталгаажуулалтад бэлтгэх үүднээс авах арга

хэмжээний төлөвлөгөө гаргаж ажиллах саналыг ОУНБДнГ-аас бидэнд хандаж, тавьсан. Үүн дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна. Ерөнхий сайдын ахлах зөвлөх байнга солигдож байна, ирсэн хүн болгон янз бүрийн ааш араншинтай, иргэний нийгмийн талаарх ойлголт нь янз бүр байна. Иймээс хуралд орж ирэхийн өмнө Санаачилгын талаар болон иргэний нийгмийн үүрэг оролцооны талаар сайн танилцуулж баймаар байна. Үүний өмнө Дэлгэрмаа зөвлөхтэй ойлголцохын даваан дээр яваад өгсөн, одоо энэ хүнтэй учраа олохгүй юм байна. Энэ хүмүүс чинь ойлгохгүй болохоор ингээд байна.

Ш.Цолмон: Туршилтын баталгаажуулалтын хувьд бүрэн эхээр орчуулж байгаа. Тухайн үед ОУНБДнГ-аас бүрэн эхээр нь орчуулах шаардлагагүй гэж хэлсэн байсан, бид зардал мөнгөгүй учраас ГОУХАН дэмжлэг үзүүлж, 80 гаруй хуудас материал орчуулагдаж байгаа, ирмэгч бид тараана. Баабар гуайн хувьд, энэ хүн олдохгүй, утсаа авахгүй юм байна лээ. Гэхдээ ямар ч байсан уулзаж, ойлгуулсан, өнөөдөр арай өөрөөр ярьж байна. Санхүүжилт орж ирвэл бид бүрэн ажиллаж боломжтой. Ажлын дэд хэсэгт орох хүнийхээ нэрийг өгөх хэрэгтэй, бид татвар, АМГ-аас оролцох хүмүүсийн нэрийг дэвшүүлнэ. Бид 5 сарын 1-нээс 6 сарын 15-ны дотор ямар нэгэн байдлаар ерөнхий чиглэлтэй болох байх гэсэн найдвартай байгаа. Эрдэнэчимэгийн асуултанд хариулах уу?

Н.Энхбаяр: Урт нэртэй хуулийн талаар асуусан байгаа, Орон нутагтай хамтарч ажиллах гэрээний загвар хоёр төрөл байгаа, үүнд өмнө нь үүсээд байсан хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор аж ахуйн нэгжүүд үүрэг хүлээж авсан баталгаажуулалтын гэрээ, Ашигт малтмалын тухай хуулийн 42-т заасан орон нутгаар нь түрээслэх гэрээ гэж байгаа. БО-ны яамтай хамтарсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Үүргийн гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо тухай бүр өөрчлөгдөж байдаг. Үүнийг хамгийн сүүлийн тоог тодруулж байж явуулъя. Ерөнхий зарчмын хувьд урт нэртэй хууль маань гурван бүсийг хамгаалалтад авсан байгаа. Нэгдүгээрт, урсгал бүрэлдэх эхийг 100 хувь хамгаална, усан сан бүхий газрын энгийн болон тусгай хамгаалалтын газрыг хамгаалалтанд авсан үүнийг үүргийн гэрээ байгуулж байгаа. Дэнчингээр байршуулж, хийх ажлыг үүргээр баталгаажуулж гэрээ байгуулж байна. Ой модны хувьд ойн тухайн хуулиараа нэг огтлолцох модыг 10 доллараар борлуулна гэдгээр хийж байгаа. Орон нутагтай хамтран ажиллах гэрээний хувьд загвар гэрээ 2016 оны 4 сарын 4-ны өдөр батлагдсан, өчигдөр ЗГХЭГ-аас албажуулж тогтоол ирсэн, холбогдох байгууллагуудад хүргүүлж байна, яамны цахим хуудсанд байршуулъя.

Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухайд, суурь өөрчлөлтөө 2014 оны 7 сарын 1-ны өөрчлөлтөөр оруулсан гэж үзэж байгаа. Одоо хэрэгжүүлэх явцад гарч байгаа хүндрэл бэрхшээлийг бага зэргийн хэмжээнд тухайн чиглэсэн зүйлүүд рүү тусгах чиглэлээр ажиллаж байгаа. Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар бол орон нутагтай хамтын ажиллагааг илүү өндөр түвшинд хүргэх чиглэлээр ажлын хэсэг гараад ажиллаж байгаа.

Хуулийн төслийн эхний хэлэлцүүлгийн Эрдэс баялагийн бодлогын зөвлөлөөр өнгөрсөн долоо хоногт хэлэлцүүлсэн. Эрдэс баялагийн бодлогын зөвлөл нь Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого болон Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу гурван талын тэгш оролцоог хангасан зөвлөл ажилладаг. Салбартай холбоотой аливаа шинэчлэл өөрчлөлтийг Зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөрүүд маань Өрийн удирдлагын тухай хуулиар зохицуулагдаж байгаа, Сангийн яамнаас хуулиа дагаж мөрдөх журмаа шинэчилж, тэр журмынхаа дагуу явж байгаа. Журамд зээл тусламж үзүүлж байгаа тал, түүнийг хүлээн авч байгаа талууд үндсэн чиглэлүүдээ гаргана, тэр нь ерөнхий хэлэлцээрт тусгагдана, хэрэгжүүлэгч байгууллага, ашиг хүртэгч байгууллага

оролцоно, төлөвлөгөөгөө удирдах хороогоор батлуулаад явна. Удирдах зөвлөл нь төлөвлөгөөгөө батладаг, түүний хэрэгжилтэн явцын болон эцсийн хяналтаа тавьдаг. Хэрэгжүүлэх ажлын ерөнхий чиглэлүүд гарсан байгаа, түүнтэй танилцаж болно.

Д.Эрдэнэчимэг: Ашигт малтмалынхуулийн ажлын хэсэг чинь яаман дээр байна уу, тэр төсөлтэй нь танилцаж, санал өгч болох уу, аль хэлтэс дээр байгаа вэ?

Н.Энхбаяр: Баатарцогт дарга дээр байгаа.

Б.Батболд: Ажлын албаны төсөв санхүүжилт хүндрэлтэй хэвээрээ байгаа юу? Тэрнийг ерөнхий сайдад оролцогч талуудаас ажлын албаны ажиллах нөхцөл, төсөв санхүүтэй холбоотой асуудлыг шийдэх талаар санал өгвөл яасан юм бэ?

Шийдвэрлэсэн нь:

1. Энэ асуудлыг 6 дугаар сарын 15-ны дотор хийж болох Ажлын төлөвлөгөөг боловсруулах дэд хэсгийг УУЯ-ны ЭЗСХО-ын хэлтсийн дарга Н.Энхбаяраар удирдуулан байгуулсугай.
2. Дэд хэсэгт орох төлөөллүүдийнхээ нэрсийг 5 дугаар сарын 1-ний дотор Ажлын албанд ирүүлсүгэй.

Хуралдаан 12,45 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУЯ-ны СТБГ-ын дарга

М.Баянмөнх

ЭЗСХО-ын хэлтсийн дарга, ОУИТБС-ын ОУ-ын Удирдах хорооны гишүүн

Н.Энхбаяр,

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан

А.Отгонтунгалаг